

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН /2024 оны жилийн эцсийн байдлаар/

№	Ажлын чиглэл	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Биелэлтийн хувь	Биелэлт дутагдалтай байсан бол түүний шалтгаан
1	Хүний нөөцийн чиглэлээр	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт нийт 36 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 5 албан хаагч ёс зүйн дэд хороонд ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны албан хаагчид байгууллагадаа, салбарт ёс зүйн зөв хандлага, хариуцлага, төлөвшлөөр сургах, манлайлах, нөлөөлөх, албан хаагчдыг авилга, албан тушаалаа урвуулан ашиглах, ёс зүйн зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн удирдлагыг төлөвшүүлэх зэрэг чиглэлээр тодорхой сургалт, арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна. Хүний нөөцийн талаар: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар сул орон тоо нөхөх, албан хаагчдын цалингийн шатлал тогтоох, ажилласан жилийг тооцон олгохдоо Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчдын тусгай шалгалт зохион байгуулах журам болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн. Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлд тус байгууллагад гарсан 2 сул орон тоог нөхөхөөр албан т тоот хүргүүлж, 2 удаагийн сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй зарлаж зохион байгуулсан. 2024 онд нийт хүний нөөцийн холбогдолтой 81 тушаал гаргаснаас: Томилсон- 4; Чөлөөлсөн -7; Буцалтгүй тусламж-4; Сахилгын шийтгэл-1; Бусад -65 тушаалыг тус тус гаргасан. Тушаалын хэрэгжилт бүрэн хангагдсан.	100	

		Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай Аймгийн засаг даргын 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/294 дүгээр захирамжаар 7 албан хаагчдын зэрэг дэвийг нэмэгдүүлсэн. Үүнд: Дэс түшмэл тэргүүн зэрэг-1; Дэс түшмэлийн дэд зэрэг-3; Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг -3 албан хаагчид тус тус зэрэг дэвийн нэмэгдлийг олгуулсан. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл жагсаалтыг агентлагийн даргын 2019 оны Б/123 дугаар тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд ГХБХБГ-т 36 албан хаагч ажиллаж байна.		
--	--	--	--	--

		Тус газрын сул орон тоонд 2 иргэнийг нэр дэвшүүлэн Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар албан бичиг хүргүүлж, тухайн албан тушаалд томилон ажиллуулж байна. Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна. Үүнд: 1. Шатлан дэвшүүлж томилсон-1 2. Төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалтаар тусгай шалгалт өгч томилогдсон-2 3. Түр орлон гүйцэтгэгч-1 4. Төрийн жинхэнэ албан хаагчийг удирдлагын хооронд харилцан тохиролцсны дагуу шилжүүлэн томилсон-1 Төрийн жинхэнэ албаны 2 сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлд 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 52, 296 дугаар албан бичгээр хүргүүлж, зарлагдаж нөхсөн. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгоор сул орон тооны зарыг цахим хуудсанд тухай бүр байрлуулан олон нийтэд мэдээлсэн. ГХБХБГ-ын албан хаагчдын ажилласан жилийн дэлгэрэнгүй судалгааг Төрийн үйлчилгээний цахим системээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллийг авч бэлтгэсэн.		
--	--	--	--	--

		2024 оны цалингийн санг 2024 оны 01 дүгээр 02-ны өдрийн А/01, 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/17 тушаалаар шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус газрын үндсэн 36 албан хаагчийн цалингийн мэдээллийг тухай бүр оруулж байна. Албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавьж, цагийн бүртгэлийг сард 2 удаа санхүүд гаргаж байна. Албан хаагчдын мэдээллийг “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем”-д 36 албан хаагчийн дэлгэрэнгүй мэдээллийг шинэчилсэн бүртгэлд оруулсан. Мөн 2024 оны 04 дүгээр сард нийт 35 албан хаагчдын дараах мэдээллийг цахим системд шинэчлэн оруулсан. Үүнд: 1. “Улсын код”-ын мэдээлэл, 2. “Ажил мэргэжлийн код”-ын мэдээлэл, 3. “Ажилтны ангилал”-ын мэдээлэл. Цахим системийн шинэчлэлийн хүрээнд ТА3-аас зөвлөмж авч, 36 албан хаагчийн мэдээллийг дахин шинэчилэн орууллаа. Шинээр томилогдсон, чөлөөлөгдсөн, шилжин ажилласан нийт 5 албан хаагчийн мэдээллийг системд бүртгэж оруулах, хасах ажлыг гүйцэтгээд байна. 2024 оны сургалт, хөгжлийн төлөвлөгөөг 2 дэд хэсэгт 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, боловсруулж тус газрын даргын 2024 оны А/20 дугаар тушаалаар батлагдсан. 2024 оны сургалт хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт: Нэг. Уулзалт, зөвлөгөөн • Хэрэгжүүлэх арга хэмжээ-2 • Хэрэгжсэн-2		
--	--	--	--	--

		Хоёр. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагч, сумын газрын даамлуудад зориулсан сургалт Хэрэгжүүлэх арга хэмжээ-17 • Хэрэгжсэн-17 1. "Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагч, 2. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2 албан хаагч, 3. "Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 3 албан хаагч, 4. Богино хугацааны захиалгат сургалтыг Удирдлагын академийн Мэргэшил дээшлүүлэх институтэд "Төрийн захиргааны удирдлага ба гүйцэтгэлийн төлөвлөлт" сургалтад 21 аймгийн ГХБХБГ-ын Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд 45 албан хаагч оролцсон. 5. Богино хугацааны захиалгат сургалт "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага ба сургалтын тогтолцоо", төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 1 албан хаагч, 6. "Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчэл" сэдэвт сургалтад 3 албан хаагч, 7. "Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах сургалт"-д хамрагдах 1 албан хаагчийг хамруулсан байна.		
--	--	---	--	--

		2024 оны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний төслийг 6 үндсэн зорилтын хүрээнд 19 арга хэмжээг төлөвлөн боловсруулж, батлуулсан. Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлж байна.		
2	Гомдол мэдээллийн, ёс зүйн зөрчлийн судалгаа	2024 онд ёс зүйн 1 гомдол, зөрчил гарсан.	-	
3	Ёс зүйн зөрчлүүдийн шийдвэрлэлтийн үр нөлөө	Өмнөх онд гарсан ёс зүйн зөрчил, гомдлын шийдвэрлэлт, авилга, албан тушаалаа урвуулан ашиглах, ёс зүйн зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээнүүдийн үр дүнд 2024 онд 1 зөрчил, гомдол бүртгэгдсэн.	100	
4	Сургалт, соён гэгээрэл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр	Сургалтын чиглэлээр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас 2024 онд зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 19 албан хаагчдыг хамруулаад байна.Тухайлбал: 1. Салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөн 2024 оны 01 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба газрын дарга болон хэлтсийн дарга нар оролцсон.4 дүгээр сарын 5-ны өдрийн “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сэдэвт сургалтад 53 албан хаагчдыг; 2. Газрын харилцааны салбарын бүсчилсэн сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 28-наас 02 дугаар сарын 03-ны өдрүүдэд Баруун бүсийн Увс аймгийн Улаангом хотод зохион байгуулагдсан. Уг зөвлөгөөнд 5 мэргэжилтэн оролцож илтгэл тавьсан. 3. 2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн оролцсон.	100	

	4. Газрын татвар, төлбөр үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн тус сургалтад 2024 оны 10 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд хамрагдсан. 5. Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн, Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд оролцсон. “ 6. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн болон сумдын газрын даамлууд сургалтад цахимаар оролцсон. 7. Санхүүгийн 2024 оны хагас жилийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлэн сургалтад Ерөнхий нягтлан бодогч оролцсон. 8. 2024 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч оролцсон. 9. 2024 оны 04 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд 3 хоногийн сургалтад Геодезийн мэргэжилтэн оролцсон. 10. 2024 оны 10 дугаар сарын 25-26-ны хооронд Архивын ажилтан, Албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнууд оролцсон. 11. 2024 оны 05 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн оролцсон. 12. 2024 оны 05 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд АТГ-аас зохион байгуулсан танхимын 1, цахимаар 1 удаагийн сургалтад тус тус хамрагдсан. 13. 2024 оны 01 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Геодезийн мэргэжилтнүүд тус тус оролцсон.		
--	---	--	--

ГХБХБГазар